


## Худалдан авах ажиллагааны үр дүн

1. Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх ажлыг “Чандмань” иргэдийн бүлгээр 4,9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авлаа.



2. “Нийтийн эзэмшлийн төв талбайн засвар, тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчээр 1 дүгээр багийн иргэн Г.Золбоотой гэрээ байгуулж 1,9 сая төгрөгөөр гүйцэтгүүллээ.



3. “3-р сургуулийн цахилгааны монтажыг хэсэгчлэн шинэчлэх”-ажлын тендерийг цахимаар зарлаж тендерт 1 компани оролцож шаардлагад нийцсэн оролцогчоор “Энхжих формат” ХХК шалгарлаа.
4. Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах ажлыг гүйцэтгэгчээр “Илчлэг Шивээ” ОНӨҮГазрыг сонгон шалгаруулж, 2018 оны 01 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сарын 31-ыг дуустал гэрээ байгуулан хог тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгүүлж байна. \байрнуудын хогийг 7 хоногт 3 удаа, гэр хорооллын хогийг 7 хоногт 2 удаа зөөвөрлөн хогийн цэгт хүргэж байна.\
5. “Өвс, тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/22 Захирамжаар байгуулж, иргэн Б.Баяртогтохтой гэрээ байгуулан 714 боодол өвсийг 5,9 сая төгрөгөөр худалдан авлаа.




6. “Малын үүлдэр угсааг сайжруулах”-ажлын хүрээнд сумын Засаг даргын А/69 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг иргэн Г.Даваадоржтой гэрээ байгуулан Керей үүлдрийн хуц-2, эм хонь хургатай 6 /эр хурга/ толгой мал худалдан авлаа.



7. “Нийтийн номын сангийн фонд болон орон нутаг судлах танхимыг тохижуулах”- ажлын хүрээнд сумын Засаг даргын А/ 38 Захирамжаар шууд байгуулагдсан ажлын хэсэг худалдан авалтыг зохион байгуулж иргэн А.Сэргэлэнтэй гэрээ байгуулан 1,5 сая төгрөгөөр 8 төрлийн үзмэр/амьтны чихмэл/ худалдан авлаа. Үүнд: Чоно, Үнэг, Дорго, Унага, Зурам, Өмхий хүрэн, ятуу шувуу, Турлиах хэрээ зэрэг болно.




8. “Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулах, зүүн гэр хорооллын худгийн байрыг засварлах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/55 Захирамжаар байгуулж гүйцэтгэгчээр “Сүмбэр зууч” ХХК-ийг шалгаруулж 9,8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажлыг ашиглалтад хүлээн авлаа.



9. “Эрүүл мэндийн төвд ЭХО томографик 4D аппарат худалдан авах” ажлын тендерийг цахимаар 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер шалгараагүй болно..Захиалагч “ИМИ”ХХК-тай 49,9 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.
10. ”3-р цэцэрлэгийн гэр цэцэрлэгийг тохижуулах /Гэр, зөөлөн эдлэл” худалдан авах барааг нийлүүлэх нийлүүлэгчээр “ОЧХИЙЦ”ХХК-тай 5,8 сая төгрөгөөр гэрээ байгуулж 6 ханатай иж бүрэн гэр-1, 30 хүүхдийн зөөлөн эдлэл хүлээн авлаа.



11. “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээ хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/34 Захирамжаар байгуулан гүйцэтгэгчээр “Энхжих формат”ХХКийг шалгаруулж 5,7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажлыг ашиглалтад хүлээн авлаа.



12. “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих, усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/35 Захирамжаар байгуулж гүйцэтгэгчээр “Илчлэг-Шивээ” ОНӨҮГазрыг шалгаруулан 2,0 төгрөгөөр гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлж байна.



13. Бэлчээрийн хортон мэрэгч устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/48 Захирамжаар байгуулж 1,0 төгрөгөөр сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрийн 10 байршилын 12 га талбайд устгах ажлыг гүйцэтгэсэн.



14. Золбин нохой, муур устгах ажлын гүйцэтгэгчийг сумын Засаг даргын А/26 Захирамжаар байгуулсан ажлын хэсэг иргэн 2-р багийн иргэн Ш.Зоригтбаатараар 0,5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан уг ажлыг зохион байгуулсан. Хаврын нохой устгалаар 23 золбин нохой устгаж ариутгал халдваргүйтгэл хийж төвлөрсөн хогийн цэгт булсан.

